

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай 16<sup>1</sup> дүгээр зүйл нэмсүгэй:

#### **“16<sup>1</sup> дүгээр зүйл. Албан татвар төлөх хугацааг хойшлуулах**

16<sup>1</sup>.1. Татварын ерөнхий хуулийн 6.1.51-д заасан хууль даган мөрдөлтийн түвшин “сайн” буюу түүнээс дээш үнэлгээтэй албан татвар суутган төлөгч хүсэлт гаргасан тохиолдолд албан татвар төлөх хугацааг нэг сар хүртэл хугацаагаар хойшлуулна.

16<sup>1</sup>.2. Энэ зүйлийн 16<sup>1</sup>.1-д заасан хугацаанд хойшлуулсан албан татвараа бүрэн төлсөн, хууль даган мөрдөлтийн түвшин “сайн” буюу түүнээс дээш үнэлгээтэй албан татвар суутган төлөгч дахин хүсэлт гаргасан тохиолдолд албан татвар төлөх хугацааг хоёр сар хүртэл хугацаагаар, сар бүр тэнцүү хэмжээгээр төлөх нөхцөлтэйгөөр хойшлуулна.

16<sup>1</sup>.3. Хууль даган мөрдөлтийн түвшин “сайн” буюу түүнээс дээш үнэлгээтэй импортын барааны мэдүүлэгч хүсэлт гаргасан тохиолдолд тухайн импортын барааны албан татвар төлөх хугацааг нэг сар хүртэл хугацаагаар хойшлуулна.

16<sup>1</sup>.4. Энэ зүйлийн 16<sup>1</sup>.3-т заасан хугацаанд хойшлуулсан албан татвараа бүрэн төлсөн, хууль даган мөрдөлтийн түвшин “сайн” буюу түүнээс дээш үнэлгээтэй импортын барааны мэдүүлэгч дахин хүсэлт гаргасан тохиолдолд тухайн импортын барааны албан татвар төлөх хугацааг хоёр сар хүртэл хугацаагаар, сар бүр тэнцүү хэмжээгээр төлөх нөхцөлтэйгөөр хойшлуулна.

16<sup>1</sup>.5. Энэ зүйлийн 16<sup>1</sup>.3, 16<sup>1</sup>.4-т заасны дагуу хойшлуулан төлөх албан татварын хэмжээ нь тухайн татвар төлөгчийн сүүлийн улиралд импортолсон ижил төрлийн бараанд төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварын сарын дунджаас хэтрэхгүй байна.

Тайлбар: “ижил төрлийн бараа” гэж Барааг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн зургаан оронгийн түвшинд нэг ангилалд хамаарах барааг ойлгоно.

16<sup>1</sup>.6. Энэ зүйлийн 16<sup>1</sup>.1, 16<sup>1</sup>.2, 16<sup>1</sup>.3, 16<sup>1</sup>.4-т заасны дагуу хойшлуулсан хугацаанд албан татвараа бүрэн төлөөгүй, эсхүл хууль даган мөрдөлтийн түвшин буурсан, эсхүл борлуулалтдаа цахим төлбөрийн баримт олгоогүй нь тогтоогдсон бол

албан татвар төлөх хугацааг хойшлуулсан шийдвэр үл маргах журмаар хүчингүй болж, хүчингүй болсон өдрөөс татварын өр хураах үйл ажиллагааг эхлүүлнэ.

16<sup>1</sup>.7.Татвар төлөгч энэ зүйлийн 16<sup>1</sup>.6-д заасны дагуу албан татвар төлөх хугацааг хойшлуулсан шийдвэр хүчингүй болсон өдрөөс эхлэн нэг улирлын хугацаанд энэ зүйлийн 16<sup>1</sup>.1, 16<sup>1</sup>.2, 16<sup>1</sup>.3, 16<sup>1</sup>.4-т заасан хүсэлтийг гаргах эрхгүй.

16<sup>1</sup>.8.Энэ зүйлийн 16<sup>1</sup>.7-д заасан хугацаанд татвар төлөгч борлуулалтдаа цахим төлбөрийн баримт олгоогүй нь тогтоогдсон бол тухайн өдрөөс эхлэн нэг улирлын хугацааг дахин тоолж эхэлнэ.

16<sup>1</sup>.9.Энэ зүйлийн 16<sup>1</sup>.6, 16<sup>1</sup>.8-д заасан зөрчил арилсан тохиолдолд татвар төлөгч дахин 16<sup>1</sup>.1, 16<sup>1</sup>.3-т заасан хойшлуулалтыг эдлэхээр хүсэлт гаргаж болно.

16<sup>1</sup>.10.Энэ зүйлд заасан албан татвар төлөх хугацааг хойшлуулах хүсэлтийг татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл, хууль даган мөрдөлтийн түвшинд үндэслэн харьяа татварын алба, гаалийн байгууллага хүлээн авснаас хойш ажлын таван өдөрт багтаан шийдвэрлэнэ.

16<sup>1</sup>.11.Энэ зүйлд заасны дагуу албан татвар төлөх хугацааг хойшлуулсан **шийдвэр гарсан** бол тухайн албан татварын өр төлөх хугацааг хойшлуулсан гэж үзэж татварын өр хураах үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй.”

**2 дугаар зүйл.**Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.2, 5.3, 5.5 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсгийн “50” гэснийг “400” гэж, 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсгийн “20” гэснийг “2.5” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.10 дахь хэсэг нэмсүгэй:

“6.10.Импортолсон суудлын автомашины гаалийн үнийн ~~100.0~~ мянган америк долларөөс **360 000 000 төгрөгөөс** давсан хэсэгт энэ хуулийн 6.3 дахь хэсэгт заасан хэмжээн дээр нэмж 33 хувийн онцгой албан татвар ногдуулна.”

Гарын үсэг